

Үйлчилгээний нөхцөл

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Их нүүдэл сургалтын удирдлагын системийн веб болон iOS, Android үйлдлийн системтэй гар утасны програм дээр үзүүлэх үйлчилгээний нөхцөлийг нийтэлж байна.
2. Системд байгаа бүхий л тэмдэгт, лого, контентууд нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан тул хуулбарлахыг хориглоно.
3. Системийг ашиглаж байгаа бүхий л хэрэглэгч үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
4. Их нүүдэл систем нь үйлчилгээний нөхцөлийг шинэчлэлт бүрт өөрчлөх эрхтэй ба үйлчилгээний нөхцөл олон нийтэд үргэлж нээлттэй байна.

ХОЁР. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

1. Хэрэглэгч нь системийг ашиглах гэрээ байгуулсан сургуулийн удирдах албан тушаалтан, багш, сурагч болон эцэг эх асран хамгаалагч байна.
2. Хэрэглэгч бүр систем рүү ордог өөрийн нууц кодоо нууцалж, нууц кодтой холбоотой бүх асуудлын хариуцлагыг өөрөө үүрнэ. Хэрэглэгч зөвхөн өөрийн нэвтрэх эрхийг ашиглан системийн үйлчилгээг авах эрхтэй.
3. Нэг Хэрэглэгч нь нэг л бүртгэлтэй байна. Нэгээс илүү бүртгэлтэй байх нь хориотой тул автомат системээр тогтоогдсон давхар бүртгэлүүд түр хаагдах болон түгжигдэх болно.
4. Хэрэглэгч нь системтэй ажиллах орчныг /интернэт, төхөөрөмж/ бүрдүүлэнэ.
5. Хэрэглэгч нь системтэй холбоотой санал гомдолыг Их нүүдэл системд хүргэх эрхтэй.

ГУРАВ. ИХ НҮҮДЭЛ СИСТЕМИЙН ЭРХ ҮҮРЭГ

1. Их нүүдэл систем системийн байнгын хэвийн ажиллагааг хангах, хэрэглэгчдийг системийг ашиглахтай холбоотой заавар зөвлөмжөөр хангах үүрэгтэй.
2. Их нүүдэл систем нь хэрэглэгчийн мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг ханган ажиллана.
3. Esis системтэй мэдээлэл солилцох үйл ажиллагааг хариуцах ба ESIS системийн буруутай үйл ажиллагаанаас гарсан алдааг Их нүүдэл систем хариуцахгүй болно.

ДӨРӨВ. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

1. Үйлчилгээний журам болон гэрээтэй холбоотой асуудлаар маргаан гарвал талууд хэлэлцээний журмаар шийдвэрлэх бүхий л арга хэмжээг авна. Хэрэв асуудлыг харилцан тохиролцоо замаар шийдвэрлэж чадахгүйд хүрвэл шүүх эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.